

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	8
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	9
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
	2.11. Шилэн дансны мэдээлэл.....	11
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
	2.13. Хязгаарлалттай санал дүгнэлт.....	11
3	Менежментийн захидал.....	12
	3.1 Хөрөнгөтэй холбоотой асуудал.....	13
	3.1.2 Илрүүлэлт:.....	13
	3.1.2 Эрсдэл:.....	13
	3.1.3 Өгсөн зөвлөмж:.....	13
	3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
	4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	14
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	16
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ЗТХЯ	Зам, Тээврийн хөгжлийн яам
СЯ	Сангийн яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТЕГ	Татварын ерөнхий газар
УТОХГ	Улсын төсвийн орлого, хяналтын газар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЦЭНГЭЛ ТАНАА

2019.03.15 № 06/479
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга материаллаг алдаагүй, үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


- Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/01155 дугаар тогтоолоор Кэй Эйч Эн Ар ХХК-ийн “Шинэ төмөр замын төсөл”-ийн ажлын гүйцэтгэлд Монголын төмөр зам ТӨХК-иас 3,370.4 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй,
- Хугацаа хэтэрсэн 51.4 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруз сууриар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Монголын төмөр зам ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

1 Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга материаллаг алдаагүй, үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/01155 дугаар тогтоолоор Кэй Эйч Эн Ар ХХК-ийн “Шинэ төмөр замын төсөл”-ийн ажлын гүйцэтгэлд Монголын төмөр зам ТӨХК-иас 3,370.4 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй,
- Хугацаа хэтэрсэн 51.4 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20

дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Монголын төмөр зам ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монголын төмөр зам ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Цэнгэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС, болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аккурэйт финанс аудит ХХК-ийн баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монголын Төмөр зам ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Аккурэйт финанс Аудит ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01/141 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монголын төмөр зам ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дэлхийд тэргүүлэгч төмөр замын тээвэрлэгч болох, Монгол Улсын төмөр замын салбарын хөгжлийг тодорхойлогч үндэсний компани болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Засгийн газрын 2008 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 189 тоот тогтоолоор Монголын төмөр зам ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төмөр замын суурь бүтэц барих
- Төмөр замын тээвэр зуучлал
- Төмөр замын тээвэрлэлт

Монголын төмөр зам ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төмөр замын тээврийн тухай хууль
- Авто тээврийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна. Харин 2018 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т төрийн өмчит аж ахуйн нэгжийн зарлагын талаар заалт нэмж өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монголын төмөр зам ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монголын төмөр зам ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монголын төмөр зам ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын үзүүлэлтийг сонгов.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн байдлаарх орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 7,933.8 сая төгрөг бөгөөд түүний нэг хувь болох 79.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг нэг хувиар тооцсон нь өмнөх онд өгсөн албан шаардлагын биелэлт хангалтгүй, хязгаарлалттай санал дүгнэлт авсан, охин компани байгуулан ажиллаж байгаа зэрэг эрсдэл байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	57,061.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	-	-	
3	Албан шаардлага өгсөн	1	51.4	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	-	-	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	-	-	
	Дүн	3	57,113.2	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Өр төлбөр

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 001/ХТ2018/01155 дугаар тогтоолоор Кэй Эйч Эн Ар ХХК-ийн “Шинэ төмөр замын төсөл”-ийн ажлын гүйцэтгэлд Монголын төмөр зам ТӨХК-иас 3,370.4 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн НББОУС 1 ийн 27–д заасны дагуу нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар бүртгээгүй байгаа тул санхүүгийн тайлангийн аудитын санал, дүгнэлтийн хязгаарлах үндэслэлд тусгасан.

Асуудал 2: Дансны авлага

Урд онд өгсөн албан шаардлагын дагуу хугацаа хэтэрсэн 51.4 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ аваагүй тул Зам, тээврийн хөгжлийн яамны 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 03/5689 тоот албан бичгийн дагуу дээрх авлагыг барагдуулах асуудлыг шийдвэрлүүлэх, албан шаардлага өглөө.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монголын төмөр зам ТӨХК-ийн “Шинэ төмөр зам” төслийн талаар авч үзэх, цаашид гүйцээн мөшгөн шалгаж тулган баталгаажуулж ажиллах шаардлагатай. Үүнд:

- Монгол Улс болон БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн дүнд “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 2010 онд БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 35.7 сая ам.долларын хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Өрийн удирдлагын хуулийн дагуу эцсийн зээлдэгчээр Монголын төмөр зам ТӨХК, дэд зээлдэгчээр ЗТХЯ, зээлдүүлэгчээр СЯ-ны хооронд гурвалсан 20 тоот гэрээг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан. Тайлант оны эцэст хуримтлагдсан хүүгийн өглөг 11,160.4 сая төгрөгт хүрсэн байна. Зээлийн эргэн төлөлтийг шалган тулган баталгаажуулах,
- Таван толгой-Сайншанд чиглэлийн төмөр замын суурь бүтцийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлэх Зүүн баян төмөр зам ХХК-ийг байгуулахаар Монголын төмөр зам ТӨХК, Дорнын төмөр зам ХХК нар хамтран ажиллаж байна.
- Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам барих Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 232 дугаар тогтоолын дагуу Нарийнсухайтын төмөр зам ХХК-тай хамтарсан төрийн өмчийн 51-ээс доошгүй хувийн оролцоотой Шивээхүрэн төмөр зам ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахаар ажиллаж байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 242 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Таван толгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын төслийг үргэлжлүүлэн гүйцэтгэх Таван толгой төмөр зам ХХК-ийг 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-д “Нэг буюу түүнээс дээш охин компанитай аж ахуйн нэгж, байгууллага ... нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргана” гэж заасны дагуу ажиллах.
- ТЕГ-ын дэргэдэх Улсын төсвийн орлого хяналтын газраас МТЗ ТӨХК-ийн 2012-2016 оны албан татварын ногдуулалт төлөлтийн байдалд хийсэн хяналт шалгалтаар торгууль алдангийн 418.4 сая төгрөгийг төлөх акт гарсан байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, ТӨБЗГ-ын тогтоолоор батлан тодотгол хийж илчит тэрэг, вагон түрээс, тээвэрлэлтээс нийт 9,299.2 сая төгрөгийн орлого олж удирдлага болон үйл ажиллагааны зардалд 8,928.1 сая төгрөгийн зардал гаргаж 371.1 сая төгрөгийн ашигтай ажиллагаагаар төлөвлөсөн.

Тайлант онд илчит тэрэг, вагон түрээсээс 6,071.1 сая төгрөг, тээвэрлэлтээс 2,618.1 сая төгрөг, хүүгийн орлого 677.1 сая төгрөг, нийт 9,366.3 орлого олж удирдлага болон үндсэн үйл ажиллагаандаа 7,933.8 сая төгрөгийн зардал гарган, валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан алдагдалтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монголын төмөр зам ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. 2018 онд шилэн дансны цахим санд мэдээллүүдийг 6 төрлийн 62 мэдээллийг байршуулснаас 7 мэдээллийг хугацаа хожимдуулсан буюу засвар оруулан байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй биелэгдээгүй байгаа тул 75 хувьтай байна гэж үзлээ.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Хязгаарлалттай санал дүгнэлт

Бид Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Санхүүгийн тайланд аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна. “Хязгаарлалттай санал дүгнэлт”-ийн үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монголын төмөр зам ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Хөрөнгөтэй холбоотой асуудал

ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 207 тоот тушаалаар батлагдсан "Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний парк шинэчлэл нийлүүлэлт" төслийн нэг хэсэг 6 нэр төрлийн 65 ширхэг тоног төхөөрөмжийн нийт өртөг 28.6 сая ам.долларын буюу 57,061.8 сая төгрөгийн хөрөнгийг эзэмшигч компанийг тогтоох асуудал шийдэгдээгүй байна.

3.1.2 Илрүүлэлт:

Өрийн удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлэх тохиолдолд тухайн салбар ... төсвийн ерөнхийлөн захирагч нь дэд зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулна", 29 дүгээр зүйлийн 29.4-т "Эцсийн зээлдэгч гэдэгт энэ хуульд заасны дагуу дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний үндсэн дээр зээлийн хөрөнгийг, хүүгийн хамт эргэн төлөх нөхцөлтэйгөөр авч байгаа Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийг ойлгоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулаагүйгээс их хэмжээний хөрөнгө эзэнгүйдэх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дэд зээлдэгч (ЗТХЯ)-тэй хамтран хөрөнгийн эзэмшигч байгууллагыг тогтоох,

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

ЗТХЯ-ны бүртгэлд байгаа бөгөөд манай компани жилд 2 удаа хадгалж хамгаалах арга хэмжээ авч ажилладаг. ТӨБЗГ-аас 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А1/167 тоот албан бичгээр ашиглаж эзэмших шаардлагагүй гэж үзсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,633,863,513.06	9,818,536,399.50
1.1.2	Дансны авлага	1,373,461,583.39	1,574,304,014.23
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	10,325,642,210.08	9,477,707,903.64
1.1.4	Бусад авлага	45,612,735.00	79,261,441.55
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	456,063,084,550.59	455,358,077,949.48
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	28,609,701,172.28	31,194,408,178.31
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	2,835,708,700.00	2,835,708,700.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	508,887,074,464.40	510,338,004,586.71
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	66,105,026,727.31	67,523,282,683.06
1.2.2	Биет бус хөрөнгө	64,641,316.57	243,973,164,877.89
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		1,000,000.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	66,169,668,043.88	311,497,447,560.95
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	575,056,742,508.28	821,835,452,147.66
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	487,279.98	1,310,623,270.86
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.3	Татварын өр	108,794,492.36	9,105,093.42
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	9,219,898,829.01	11,160,424,735.05
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	3,345,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,329,180,601.35	12,483,498,099.33
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	86,629,512,300.80	94,331,523,507.20
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	86,629,512,300.80	94,331,523,507.20
2.2	Өр төлбөрийн нийт дүн	95,958692,902.15	106,815,021,606.53
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	139,351,735.55
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	516,982,356,207.67	760,872,017,990.37
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-58,611,965,116.14	-66,718,597,699.39
2.3.11	Эздийн өмчийн дүн	479,098,049,606.13	715,020,430,541.13
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	575,056,742,508.28	821,835,452,147.66

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,798,095,009.72	2,618,057,475.32
2	Борлуулалтын өртөг	1,960,611,484.03	2,523,345,427.48
3	Нийт ашиг(алдагдал)	-162,516,474.31	94,712,047.84
4	Түрээсийн орлого	4,361,792,763.87	6,071,096,630.78
5	Хүүгийн орлого	1,231,239,133.76	677,108,987.15
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,704,898,843.38	3,843,720,895.42
11	Санхүүгийн зардал	1,521,062,393.07	1,550,464,480.98
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,342,606,979.07	-8,509,090,285.19
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-16,336,575.44
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-35,707,102.75	138,131,653.12
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,511,454,063.19	-6,938,562,918.14
19	Орлогын татварын зардал	123,123,913.31	67,710,898.71
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,388,330,149.88	-7,006,273,816.85
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,388,330,149.88	-7,006,273,816.85
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	2,388,330,149.88	-7,006,273,816.85
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	2,388,330,149.88	-7,006,273,816.85

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60		402,087,474,939.49	-34,631,906,622.32	388,183,226,831.77
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60		402 087 474 939,49	-34,631,906,622.32	388,183,226,831.77
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)					-
5	Бусад дэлгэрэнгүй орлого			114,894,881,268.18	-26,368,388,643.70	88,526,492,624.48
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг				2,388,330,149.88	2,388,330,149.88
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-	-
9	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60		516,982,356,207.67	-58,611,965,116.14	479,098,049,606.13
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
11	Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60		516,982,356,207.67	-58,611,965,116.14	479,098,049,606.13
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-1,100,358,766.40	-1,100,358,766.40
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-25,602,861.30		-25,602,861.30
14	Өмчид гарсан өөрчлөлт					-
15	Зарласан ногдол ашиг					
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-7,006,273,816.85	-7,006,273,816.85
17	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		139,351,735.55	243,915,264,644.00		244,054,616,79.55
18	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	760,872,017,990.37	-66,718,597,699.39	715,020,430,541.13

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,911,121,991.04	9 014 561 557,72
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,874,694,355.43	8,609,681,680.80
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	3,711,377.00	2,770,647.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	32,716,298.61	402,109,229.92
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,751,123,314.18	9,418,820,985.36
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,200,932,798.18	2,209,853,785.82
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	526,874,958.25	597,143,982.34
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	181,019,601.22	264,513,791.79
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	22,298,620.00	26,431,627.51
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,587,067,594.54	36,632,037.33
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	257,110,445.42	500,000,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,403,230,861.64	1,546,573,270.19
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	572,588,434.93	4,237,572,490.38
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,840,001,323.14	-404,259,427.64
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	801,682,972.95	677,108,987.15
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	801,682,972.95	677,108,987.15
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		171,192,676.90
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		1,000,000.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		170,192,676.90
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	801,682,972.95	505,916,310.25
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		-
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү	-90,702,707.14	83,016,003.83
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-3,129,021,057.33	184,672,886.44
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,762,884,570.39	9,633,863,513.06
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,633,863,513.06	9,818,536,399.50

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.03.15	Аудитын нэр: Монголын төмөр зам ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодрууллагад хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/58/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Монголын төмөр зам ТӨХК	Сая төгрөгөөр	

№	Аудитын чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
					Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6
1	Урд оны аудитын зөвлөмж, албан шаардлагын биелэлт-Авлага	Урд оны өгсөн албан шаардлагын дагуу төлөгдөх хугацаа хэтэрсэн 54.8 сая төгрөгийн дансны авлагаас 2.4 сая төгрөг барагдуулж 52.4 сая төгрөгийг барагдуулаагүй байна. Аудитын ажил дуусгавар болж байх үед Л.Цэнгэлийн сургалтын төлбөрийн үлдэгдэл 0,9 сая төгрөг бүрэн төлөгдсөн.	51.4	Албан шаардлага	Захирал, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Д.Даваадорж
2	Хөрөнгө	БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх” төслийн хэсэг болох 28.6 сая ам.доллар буюу 57,061.8 сая төгрөгийн 6 нэр төрлийн 65 ширхэг тоног төхөөрөмжийн хөрөнгийг эзэмшигч компанийг тогтоох асуудал шийдэгдээгүй, дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулагдаагүй.	57,061.8	Зөвлөмж өгөх	Захирал, Нягтлан бодогч	Б.Цэнгэл, Д.Даваадорж

